



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 469


Улаанбаатар хот

“Стратеги төлөвлөгөө батлах тухай”

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.1.4, 3.2, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1, 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө (2022-2025)”-г хавсралтаар баталсугай.
2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, жил бүр тайлагнаж байхыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.
3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг 2 жил тутамд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж танилцуулахыг Дотоод аудитын хэлтэс /Н.Соёлмаа/-г үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518001054



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2022–2025 ОН)



2022 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
1.1 ОРШИЛ.....	3
1.2 БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	5
1.3 ЗОХИЦУУЛАЛТТАЙ САНХҮҮГИЙН САЛБАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД.....	7
1.4 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА.....	9
1.5 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ	10
1.6 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ	10
1.7 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН	10
1.8 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ	11
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	12
ГУРАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	14
3.1 ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ.....	14
3.2 ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ.....	15
3.3 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ.....	18
ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА	19
ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	19
ЗУРГАА. ҮНЭТ ЗҮЙЛС	19
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	20
НАЙМ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2022-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
ЕС. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА ХОЛБОО, ЗУРАГЛАЛ	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Стратеги төлөвлөгөө боловсруулах зарчим.....	10
Хүснэгт 2. Мандатын шинжилгээ.....	12
Хүснэгт 3. Дотоод орчны шинжилгээ	14
Хүснэгт 4. Гадаад орчны шинжилгээ	16
Хүснэгт 5. Орчны шинжилгээний үр дүн	18
Хүснэгт 6. Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт	40

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн хөгжлийн банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БОНЗ	Байгал орчин, нийгэм, засаглал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТоС	Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
ҮЧҮ	Үндсэн чиг үүрэг
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ФАТФ	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага
AFI	Alliance for Financial Inclusion/ Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
АТМ	Automated teller machine /Автомат теллер машин/
ESG	Environmental, Social, Governance /Байгаль орчин, нийгэм, засаглал/
JICA	Japan International Cooperation Agency /Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага/
IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 ОРШИЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг Улсын Их Хурлаас 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан билээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2012-2016”, “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө 2018-2021”-г тус тус батлан салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, санхүүгийн зах зээлд оролцогчдыг чадавхжуулах, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад анхаарч ажилласан.

Тухайлбал, “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө 2018-2021”-нд тусгасан үндсэн 6 зорилгын хүрээнд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх хяналт зохицуулалтын бодлогын холбогдох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, бизнес эрхлэгч нарт уян хатан таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн зах зээлд нэвтэрч буй дэвшилтэт технологийг бодлогоор дэмжих, эрсдэлийн удирдлага, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох талаар стратегийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төлөвлөгөөт жилүүдэд хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулах, нэр төрлийг олшруулах, хүртээмжийг тэлэх цогц бодлогыг хэрэгжүүлсэн. Хөрөнгийн зах зээлийн хувьд санхүүжилт татах сувгийг нэмэгдүүлэхээр “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталж, арилжаалах бүтээгдэхүүн үйлчилгээний стандарт нөхцөлийг тогтоох эрхийг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэх холбоонд шилжүүлж компаниудын хувьд хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах, биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох, хаалттай өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээл үүсэх боломжийг бүрдүүлсэн.

Үнэт цаасны арилжааны дараа төлбөр тооцоог T+2 горимд шилжүүлж, төлбөрийн эсрэг нийлүүлэлт /DvP/ зарчмыг нэвтрүүлсэн бол мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны зохицуулалтыг олон улсын жишгийн дагуу болгосон.

Үнэт цаасны давхар бүртгэлийн журамд хөрөнгө оруулагчид дотоодын болон гадаадын биржүүдийн хооронд үнэт цаасаа чөлөөтэй хөрвүүлэн арилжаалах зохицуулалтыг бий болгож, өмчлөх эрхийн бүртгэлийн холимог тогтолцоо бий боллоо. Дээрх зохицуулалтын хүрээнд Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эрдэнэс Ресурс Девелопмент Корпорэйшн”, “Степ Голд” компаниуд хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн гараад байна. Мөн “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийгэд санал болгон арилжих тухай журам”-ыг баталлаа.

Үнэт цаасны бүртгэлийн болон компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн баталж, хөрөнгийн зах зээлд анх удаа анхдагч зах зээлийг андеррайтер төвтэй тогтолцоонд амжилттай шилжүүлэв. Ингэснээр аж ахуйн нэгжүүд хямд зардлаар

хөрөнгийн зах зээлд бонд, хувьцаа гаргах замаар урт хугацааны санхүүжилтийг татан төвлөрүүлэх боломж бололцоо бүрдсэн.

Ногдол ашгийг жижиг хувьцаа эзэмшигч нарт чирэгдэлгүй хурдан тараахын тулд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкны дансанд байршуулах зохицуулалт бий болгосон.

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-уудад даатгалын эрсдэлийг тархаан байршуулах, хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулж, даатгалын компанийн нийт хөрөнгө, нөөц сангаас банкны харилцах, хадгаламжид байршуулах дээд хувийг 10.0 хувиар бууруулан, компанийн өрийн хэрэгсэл болон Монголын хөрөнгийн биржийн нэгдүгээр ангиллын хувьцаа хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 10.0 хувиар нэмэгдүүлснээр даатгалын компаниудын олон талт хөрөнгө оруулалтад хөрөнгөө байршуулах боломжийг бүрдүүлэв.

Энэ хүрээнд даатгалын компаниуд "Компанийн өрийн хэрэгсэл" болон хувьцаа хэлбэрээр хөрөнгө оруулалтад 190.0 орчим тэрбум төгрөг хүртэлх хөрөнгийг байршуулах боломжтой болсон. “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг баталж, зах зээлийн ёс зүйн зарчим, баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж, зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй болж, мөрдөн хэвших, хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгосон.

Ковид-19-ийн эрсдэл, учрах хохирлыг бууруулах даатгалын 5 шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрч 22.3 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалд 17,598 иргэн, албан хаагч (богино хугацааны үнэ төлбөргүй даатгалд хамрагдсан 82.0 мянга орчим иргэнийг оруулаагүй дүн) хамрагдаж, 619.5 сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрсөн ба 747 даатгалын тохиолдолд 949.9 сая төгрөгийн нөхөн төлбөр олгогдсон байна.

Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ болон Хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/-ны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд зээлийн ангиллыг бүртгэх хугацааны үзүүлэлтүүдийг сулруулах өөрчлөлт оруулсан. Үүний үр дүнд үйл ажиллагаа нь доголдсон 445.5 мянган зээлдэгчийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, 496.2 тэрбум төгрөгийн зээлийн ангилал буурахаас сэргийлсэн.

“Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталж, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг ашиглан харилцагчийг таньж мэдэх, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, и-баримт олгох, харилцагчийн мэдээллийг үнэн зөв нийлүүлэх боломж бүрдлээ.

УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын дагуу Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д 2 ч удаа зохицуулалтын өөрчлөлтүүдийг оруулсан. 2021 оны байдлаар нийт 241 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд 33.7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаснаар 68.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орны жагсаалтаас гарахад Санхүүгийн зохицуулах хороонд шууд хамаарах зөвлөмжүүдийн хэрэгжилтийг бүрэн биелүүлэх хүрээнд Үл хөдлөх, үнэт эдлэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэн тусгай зөвшөөрөл олгож, УИХ-аас Виртуал хөрөнгийн тухай хуулийг батлуулж, салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах, салбарын эрсдэлийн үнэлгээг хийх, эрсдэлд суурилсан зайны болон газар дээрх хяналт шалгалт гэсэн 4 чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна.

Цаашид Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбаруудын хөгжлийг бодлогоор дэмжин олон тулгуурт санхүүгийн зах зээлийн тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө (2022-2025 он)-г боловсрууллаа.

1.2 БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2021 онд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 24.0 хувьд хүрч үүнээс, хөрөнгийн зах зээлийн үнэлгээг ДНБ-д харьцуулсан дүн 15.3 хувь, даатгалын зах зээл 1.1 хувь, ББСБ 6.9 хувь, ХЗХ-ны салбар 0.7 хувьтай байна. Санхүүгийн зохицуулах хороо нь зохицуулалт хяналтын чиг үүргийн хүрээнд 2021 онд 3,440 зохицуулалттай этгээд, 2,403 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллалаа. 2018 онтой харьцуулахад зохицуулалттай этгээдүүдийн тоо 46.6 хувиар буюу 1,093-аар нэмэгдсэн бол даатгалын төлөөлөгчийн тоо 1.1 хувиар буурсан байна. Зохицуулалттай этгээдүүдийг салбарын ангиллаар авч үзэхэд, үнэт цаасны зах зээлд бүртгэлтэй 314 ХК, 265 мэргэжлийн оролцогчид, даатгалын зах зээлд нийт 322 даатгалын компани, мэргэжлийн оролцогчид, аудитор, 534 ББСБ, 209 ХЗХ, 248 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 476 хувь хүн, хуулийн этгээд, тэдгээрийн 1072 салбар тус тус үйл ажиллагаа явуулж байна.

1. Хөрөнгийн зах зээл

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого, зохицуулалтын олон арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсний үр дүнд 2021 оны эцэст зах зээлийн үнэлгээ 5,982.9 тэрбум төгрөг, хувьцааны хөрвөх чадвар 5.1 хувь, харин хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 3.8 хувь, ТОП-20 индекс 44,411.6 нэгжид хүрч хөрөнгийн зах зээл үүсэж хөгжсөн 30 жилийн түүхэндээ хамгийн дээд түвшнийг тогтоолоо.

2021 онд нийт 1,414.2 тэрбум төгрөгийн үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж, нийт арилжааны 74.1 хувийг компанийн бонд, 21.6 хувийг хувьцаа, 4.0 хувийг хөрөнгө оруулалтын сан, 0.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас тус тус эзэлж байна. Түүнчлэн 2021 онд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн нийт 5 төрлийн 794.6 тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүн арилжаалсан байна.

2. Даатгалын зах зээл

2021 онд даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 425.4 тэрбум төгрөгт, нөөц сан 193.7 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Ердийн болон урт хугацааны даатгалын салбар 2021 онд 132.8 их наяд төгрөгийн даатгалын үнэлгээтэй 3,573,869 зүйлийг даатгаснаар нийт хураамж 243.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. Үүнээс давхар даатгалын хураамжид 84.4 тэрбум төгрөг төлсөн байна. Даатгалын хохирлын нөхөн төлбөрт 70.0 тэрбум төгрөгийг олгосон нь нийт хураамжийн 28.3 хувийг эзэлж байна.

3. Банк бус санхүүгийн байгууллагын салбар

2021 онд ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2,709.9 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 2.0 их наяд төгрөгт тус тус хүрсэн бөгөөд, нийт зээлийн үлдэгдлийн 87.5 хувийг иргэдийн зээл, 12.5 хувийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Салбарын нийт зээлдэгчдийн тоо 1.7 сая бөгөөд үүнээс финтекийн зээлдэгчид 1.3 сая буюу нийт зээлдэгчдийн 80.4 хувийг эзэлж байна. Нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.8 сая болж өссөнөөс финтекийн харилцагчдын тоо 4.4 сая байгаа нь нийт харилцагчдын 92.1 хувийг эзэлж байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ 1.2 сая төгрөг бол финтекийн гар утас болон аппликейшнээр олгосон дундаж зээлийн хэмжээ 228.3 мянган төгрөг байна. Зээлийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2.7 хувь болсон. Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын үр дүнд 2021 оны байдлаар ББСБ-уудын зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ буурч нийт зээлийн 7.0 хувь буюу 140.2 тэрбум төгрөгт хүрсэн.

4. Хадгаламж, зээлийн хоршооны салбар

2021 онд 209 ХЗХ 75,400 гишүүддээ санхүүгийн үйлчилгээ үзүүлж, салбарын нийт хөрөнгө 291.2 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнд гишүүдийн хадгаламжийн хэмжээ 203.6 тэрбум төгрөг буюу 70 хувийг эзэлж байна. Нийт зээлийн үлдэгдэл 213.4 тэрбум төгрөгт хүрснээс 3.5 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Салбарын нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 33,600 байгаа бол зээлдэгчдийн тоо 38,016 байна. Хадгаламжийн жигнэсэн сарын дундаж хүү 1.24 хувь, зээлийн жигнэсэн сарын дундаж хүү 2.16 хувь байна.

5. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар

2021 онд 248 ҮХЭХЗ-ын байгууллага нийт 6,274 хэлцлээр 1,302.5 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 852.6 тэрбум төгрөгөөр худалдах, худалдан авах үйл ажиллагааг зуучилсан. Харин 2,114 хэлцлээр 186.4 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 23.6 тэрбум төгрөгөөр хөлслүүлж, түрээслүүлэх үйл ажиллагааг зуучилсан байна.

6. Үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар

Тайлант онд үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчид нийт 694.4 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдаж, 583.9 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдан авчээ. Үнэт эдлэлийн борлуулалтын И-баримтын мэдээгээр тайлант онд давхардсан тоогоор 301 үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь 8,961 харилцагчид 16,891 бүтээгдэхүүнийг 10.8 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.

7. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргасан олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмжийн Зөвлөмж 15 /шинэ технологи/-д улс орнууд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын тусгайлсан бодлого зохицуулалтыг бий болгох, хяналт тавих шаардлагатай гэж заасан.

ФАТФ-ын Зөвлөмж 15-ыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлаас Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар 17-ны өдөр баталж, холбогдох харилцааг зохицуулсан журмуудыг батлах эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгосон.

Дээрх үүргийг биелүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл зохицуулалттай холбоотой нийт 8 журам, зааврыг батлаад бүртгэх үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргагч болон түүний санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг хууль, журмын шаардлага хангасан эсэхийг тогтоох, бүртгэх, цаашид салбарын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, судалгаа, шинжилгээ хийх зэрэг чиг үүргийг гүйцэтгэх зорилгоор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс байгуулагдсан.

8. Сэндбоксын орчин

Финтек бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, зохицуулалтыг бий болгох “Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагууд буюу Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-63/64/32/А/27 тоот тушаалаар баталсан.

Сэндбоксын зөвлөлийн дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А251/252 дугаар хамтарсан тушаалаар баталсан ба Хорооны даргын 2021 оны 256 дугаар тушаалаар Зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан.

“Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-ын дагуу сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авах, турших чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан сэндбоксын орчинд туршилт хийх финтект суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийт 13 хүсэлт хүлээн авсан ба шаардлага хангасан 2 бүтээгдэхүүнийг туршилтад оруулсан. Мөн түүнчлэн “Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-ын 3 дугаар хэсэг, “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.12-т сэндбоксын орчинд финтек бүтээгдэхүүн, үйлчилгээг туршихад сэндбоксын зөвлөл ба нэгж ажиллана гэж заасны дагуу “Сэндбоксын алба” байгуулагдсан.

1.3 ЗОХИЦУУЛАЛТТАЙ САНХҮҮГИЙН САЛБАРТ ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

Хөрөнгийн зах зээл:

- Ковид-19 цар тахлын макро эдийн засаг, нийгмийн хөгжилд учруулах сөрөг нөлөөнөөс шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжийн ашиг, орлогын түвшин буурснаар тэдгээрийн дотоодын хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо багасаж, зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар буурах;
- Банкны салбарын реформтой холбогдуулан банкны системд нөлөө бүхий банкнууд нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагааг амжилттай хэрэгжүүлж чадахгүй тохиолдолд төрийн зохицуулагч байгууллагын нэр хүнд унах, хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл буурах;

- Үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо бүрэн дараа төлбөрт шилжиж эхлэхтэй холбогдуулан төлбөрийн тасалдал /Default/ үүсэх, төлбөрийн баталгааны сангийн хуримтлуулсан хөрөнгө хүрэлцэхгүй байх, улмаар төлбөр тооцоо хийгдэлгүй системийн эрсдэл үүсэх.

Даатгалын зах зээл:

- Эдийн засгийн өсөлт удааширсантай холбоотойгоор даатгалын салбарын голлох үзүүлэлтүүд буурч, даатгалын салбарын нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө багасах, даатгалын хүртээмж буурах;
- Байгалийн гамшгийг урьдчилан таамаглах боломжгүй бөгөөд учруулах хохирол нь даатгалын компанийн хөрөнгийн чадавхаас нэлээдгүй өндөр байх магадлалтай тул даатгалын салбарт үзүүлэх сөрөг нөлөө их байх;
- Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчдын мэргэшсэн бус байдал, бүтээгдэхүүн, үйлчилгээний сэтгэл ханамжгүй байдлаас шалтгаалан зах зээлд итгэх олон нийтийн итгэл, нэр хүнд сул;
- Ковид-19 цар тахлын үр нөлөөгөөр иргэд даатгуулагчдын санхүүгийн чадвар буурснаар даатгалын эрэлт, хамрагдалт буурах.

Банк бус санхүүгийн байгууллагын салбар:

- Финтекийн харилцагчдын мэдээллийн аюулгүй байдал алдагдах;
- Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан салбарын үйл ажиллагаа доголдох, салбарын активын чанар муудах, улмаар салбарт томоохон эрсдэлийг бий болгох;
- Бизнесийн салбарын уналт, ачаа тээврийн саатал, зохицуулалт хангалтгүй зээлдэгч нар зээлээ төлж чадахгүй байх, улмаар өрийн дарамтад орох.

Хадгаламж, зээлийн хоршооны салбар:

- Финтекийн компаниуд зах зээлд ихээр нэвтэрч, харилцагчдын тоо огцом нэмэгдэж байгаатай холбоотой ХЗХ-дын зах зээл хумигдаж болзошгүй;
- 4 ХЗХ буюу 1.8 хувь нь салбарын нийт хөрөнгийн 64 хувийг бүрдүүлдэг ба хөрөнгийн төвлөрөл өндөр;
- Санхүүгийн хүртээмжийн түүвэр судалгаанд хамрагдагсдын 48 хувь нь санхүүгийн төлөвлөлт хийдэггүй, санхүүгийн хамгаалалт сул гэж хариулсан 59 хувь байгаа нь санхүүгийн эрсдэлд орох өндөр магадлалтай.

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбар

- Хил гааль хаагдсаны улмаас тээврийн болон барилгын материалын үнэ нэмэгдсэнээр байрны үнэ өсөх;
- Шинээр баригдаж буй барилгуудын үнийг нэмэхгүйн тулд хямд материал ашиглах эрсдэл үүсэх;
- Үнийн хөөсрөл бий болох.

Үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар:

- Импортын бүтээгдэхүүн нь сонголт ихтэй, хямд үнэ, чанартай байгаа тул зах зээлээ алдах;

1.4 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 310 дугаар тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2018-2021 он)”-г баталсан бөгөөд тус Хорооны дотоод хяналтын хэлтсээс стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 87.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгджээ.

Цаашид Санхүүгийн зохицуулах хорооны 2022-2025 он хүртэл хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөг ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлоох зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "АЛСЫН ХАРАА-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй тус тус уялдуулан боловсруулах эрх зүйн шаардлага үүссэн.

Мөн олон улсын сайн туршлага, стандартыг нэвтрүүлэх, салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэж, санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн байгууллагууд чадавхиж үйл ажиллагааны хүрээгээ тэлсэн, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдсэн, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэхэд эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлсэн хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн санхүүгийн зохицуулагч байгууллага болох практик шаардлага тавигдаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 338 тоот тушаалаар “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө (2022-2025 он)-г” боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, хөгжлөөрөө тэргүүлэгч, Монгол Улстай санхүүгийн зах зээлийн хөгжлөөр ойролцоо, хөрш зэргэлдээ зэрэг 14 улс орны 23 ижил төстэй санхүүгийн зохицуулагч байгууллагуудын болон Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагуудын стратеги төлөвлөгөө, алсын хараа, эрхэм зорилго, зорилго, зорилтуудыг судалж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт болох “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Ажлын хэсэг дээрх бодлогын баримт бичгүүд болон тулгарч буй нөхцөл шаардлага, судалгаанууд дээр үндэслэн “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө (2022-2025 он)”-г боловсруулахдаа Хорооны дотоодод болон салбар бүрд тулгамдсан асуудлыг тодорхойлж, орчны болон мандатын шинжилгээг хийж, банкнаас бусад санхүүгийн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийг дэмжих, зохицуулалтын салбарын эрсдэлийн удирдлага, салбар хоорондын уялдаа холбоо, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах тогтолцоо, мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн алсын хараа, эрхэм зорилго, зорилго, зорилт, арга хэмжээг тодорхойлсон.

Ажлын хэсэг нийт долоон удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэг хийх явцад алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, зорилгоо тодорхойлж, улмаар газар, нэгж тус бүрээс санал дүгнэлт, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг авч, ирүүлсэн санал, зөвлөмжийг тусган эцэслэн боловсруулалт хийж гүйцэтгэсэн.

1.5 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

Энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа тодорхой байх, хэмжигдэхүйц байх, хүрч болохуйц байх, бодит зүйлд чиглэсэн, нөөцийг харгалзсан, учир холбогдолтой байх, цаг хугацаа тодорхой байх гэсэн зарчмыг баримталсан.

Хүснэгт 1. Стратеги төлөвлөгөө боловсруулах зарчим

S	M	A	R	T
Specific	Measurable	Attainable	Relevant	Time-based
Тодорхой байх	Хэмжиж болохуйц байх	Хүрч болохуйц байх	Бодит зүйлд чиглэсэн, нөөцийг харгалзсан, учир холбогдолтой	Цаг хугацаа тодорхой байх

Тус стратеги төлөвлөгөөг Санхүүгийн зохицуулах хорооны цаашдын хөгжлийн хандлага, 2022-2025 онд баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг гаргах зорилгоор боловсруулж, уг зорилгод хүрэхийн тулд дараах 5 алхмыг баримтлав. Үүнд:

- судалгаа, дүн шинжилгээнд үндэслэх;
- хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх;
- өнөөгийн байдалд орчны шинжилгээ хийж, давуу, сул тал болон боломж, аюулыг тодорхойлох;
- зорилго, стратегийн зорилт, дэд зорилтыг нарийвчлан тогтоох;
- стратеги төлөвлөгөө боловсруулах онол, загварыг баримтлах;
- батлагдсан эрх зүйн баримт бичиг, бодлого, хөтөлбөртэй нийцүүлэх;
- ижил төстэй зохицуулагч байгууллагуудын туршлагыг судлах.

1.6 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай салбарын үйл ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөн энэхүү стратеги төлөвлөгөөний зорилго зорилтуудыг 2022-2025 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1.7 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН

Энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Зохицуулалтын салбарын эрх зүйн орчин, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц сайжирч, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжих орчин бүрдэж, эрсдэлд суурилсан болон нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоо нэвтэрч, санхүүгийн салбарын тогтвортой байдал хангагдаж санхүүгийн зах зээл тэлнэ.
- Санхүүгийн зах зээлд дэвшилтэт технологи нэвтэрч, зах зээлийн хүртээмж нэмэгдэж, нээлттэй, ил тод байдал, хариуцлага сайжирч, хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдсан, иргэдийн зах зээлд итгэх итгэл нэмэгдсэн байна.

- Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, байгууллагын соёл төлөвшин, хамтын ажиллагаа өргөжсөн, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна.
- Олон улсын болон дотоодын байгууллагуудын дунд Санхүүгийн зохицуулах хорооны нэр хүнд дээшилж, байр суурь бэхэжнэ.

1.8 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж үнэлнэ:

- Зах зээлийн судалгаа хөгжлийн газар стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр биелэлтийг тайлагнана.
- Бодлогын газрууд арга хэмжээний биелэлтийг салбар бүрээр жил бүр нийт хамт олонд танилцуулна.
- Дотоод аудитын хэлтэс стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь Санхүүгийн зохицуулах хороонд хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээгээр тодорхойлогдоно. Энэ нь алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлох ажлын хүрээг тогтоож өгөх бөгөөд дараах хоёр алхмын хүрээнд шинжилгээг хийнэ. Үүнд:

1. Хуулиар олгогдсон үндсэн чиг үүрэг;
2. Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад чиг үүрэг.

Хүснэгт 2. Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		26
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	16 /Хөрөнгийн зах зээлтэй холбоотой 7, даатгалын салбартай холбоотой 5, банк бус санхүүгийн салбартай холбоотой 5, хоршооны салбартай холбоотой 1/
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	10
Ерөнхий чиг үүрэг-1: Хуулиар олгогдсон үндсэн чиг үүрэг		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах	Санхүүгийн болон санхүүгийн бус зах зээлийн эдийн засаг дахь үйлчилгээний хүртээмж, үр ашиг, тогтвортой байдлыг ханган өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	Цахим хөгжлийн яам
	Санхүүгийн болон санхүүгийн бус салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, зах зээлд оролцогчдын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах	Дэд бүтцийн байгууллагууд, холбоод
	Санхүүгийн болон санхүүгийн бус салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн үрээнд шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангуулахтай холбоотойгоор хяналт шалгалтын бодлогыг хэрэгжүүлэх	-
	Зах зээлийн шударга, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах, үнэлэх	-
ҮЧҮ-2: Санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг зохицуулах	Зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах	-
	Зохицуулалттай этгээдүүдийн шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээг тогтоох	-
	Зах зээлд оролцогчдод тавигдах нөхцөл шаардлагыг үйл ажиллагааны онцлогтой уялдуулах оновчтой тогтоох, хөнгөвчлөх замаар тэдгээрийг дэмжих	Төрийн эрх бүхий байгууллага
	Олон улсын стандартыг судлах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж санхүүгийн зах зээлийг тэлэх	Олон Улсын санхүүгийн

		зохицуулагч байгууллага
ҮЧҮ-3: Холбогдох хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих	Хяналт шалгалтын бодлогын баримт бичгийг мөрдөх, хэрэгжүүлэх	-
	Эрсдэлийн хэмжээнээс хамааруулж хяналт шалгалтын давтамж, цар хүрээг үнэлж, тодорхойлох	-
	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг эрчимжүүлэх, сайжруулах зорилгоор технологид суурилсан программ хангамжийг нэвтрүүлж, тогтолцоог сайжруулах	Мэдээлэл технологийн компани
	Зайны болон газар дээрх хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгах, шаардлагатай арга хэмжээг авах	-
ҮЧҮ-4: Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах	Иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллээр хангах ажлыг санхүүгийн зах зээлд оролцогчид, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах	Төрийн бус байгууллага
	Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх процессыг цахимжуулах, хялбар механизмыг бий болгох	Мэдээлэл технологийн компани
	Харилцагчийн мэдээлэл, хөрөнгийг аюулгүй байдлыг хангах зорилгоор цахим халдлагаас хамгаалах, зохицуулалттай этгээдүүдийн мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулж, хүний нөөцийг чадавхжуулах	Мэдээлэл технологийн компани
	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд зохицуулалттай этгээдүүдийн засаглал, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	Дэд бүтцийн байгууллага, холбоод
Ерөнхий чиг үүрэг-2: Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад чиг үүрэг		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Гадаад харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх	Олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Олон Улсын санхүүгийн зохицуулагч байгууллага
	Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой харилцан үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, технологид суурилсан дундын мэдээллийн санг үүсгэх	Цахим хөгжлийн яам
	Олон улсын санхүүгийн зах зээлийн оролцогчидтой олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, байр сууриа бэхжүүлэх	Олон Улсын санхүүгийн зохицуулагч байгууллага
	Олон нийтийн мэдээллийн байгууллагатай СЗХ-ны үйл ажиллагааг таниулах, олон нийтэд мэдээ мэдээллийг шуурхай хүргэх	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
ҮЧҮ-2: Байгууллагын дотоод үйл ажиллагааны жигд байдлыг хангах	Ёс зүйн кодыг хэрэгжүүлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэх	-
	Чадахуйд суурилсан зарчмаар хүний нөөцийг бүрдүүлэх, албан хаагчийг дэвшүүлэх, шилжүүлэх, чөлөөлөх	-
	Тасралтгүй суралцах, хөгжих тогтолцоог бүрдүүлэх	-
	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн хамгааллыг сайжруулах	-

ГУРАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо нь хуулиар хүлээсэн санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад түргэн шуурхай хүргэхэд нөөц, боломжоо дайчлан ажилладаг төрийн байгууллага юм.

Орчны шинжилгээний зорилго:

Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхийн тулд өөрсдийн давуу ба сул талыг шинжлэх, ирээдүйд гарч болох нөхцөл байдлыг урьдчилан таамаглахын тулд боломж, аюул заналыг шинжлэхэд оршино.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг дор дурдсан байдлаар тодорхойлж байна.

3.1 ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчны шинжилгээг хийхдээ Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт, соёл, санхүү, хүний нөөц, технологи зэрэг хүчин зүйлсийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойлсон. Үүнд:

Хүснэгт 3. Дотоод орчны шинжилгээ

Давуу тал	Сул тал
1. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, СТРАТЕГИ	
<ul style="list-style-type: none"> • Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратеги тодорхойлсон; • Эрхэм зорилго, стратеги нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, батлагдсан бодлого, хөтөлбөр, бусад эрх зүйн баримт бичгийн зорилтуудтай уялдсан; • Байгууллагын алсын хараа, үнэт зүйлс, үндсэн зарчмаа томъёолсон. 	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны зарим чиглэл, стратегиа оновчтой тодорхойлоогүй.
2. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
<ul style="list-style-type: none"> • Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаал төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд хамаарна; • Байгууллагын зорилго, үйл ажиллагааг дүрмээр зохицуулж өгсөн; • Улсын хэмжээнд танигдсан, нэр хүндтэй, тогтвортой бүтэц, зохион байгуулалттай; • Ажлын байрны тодорхойлолтыг албан тушаал бүрээр боловсруулсан; • СЗХ-нд ёс зүйн хороо ажилладаг; • ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан хаагч бүр боловсруулж, хэрэгжүүлдэг. 	<ul style="list-style-type: none"> • Орон тооны дээд хязгаарыг Засгийн газраас баталдаг учраас шаардлагатай орон тоог нэмэх боломжгүй; • Зарим нэгжийн үйл ажиллагааны давхцалыг арилгах шаардлагатай; • Жендэрийн харьцаа болон залгамж халаа алдагдсан.
3. ДОТООД ДҮРЭМ, ЖУРАМ	
<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа нь бие даасан хуулиар зохицуулагдсан статустай; • Байгууллагын дотоод дүрмийг баталж мөрдүүлж байна; • Байгууллагын соёл тодорхой хэмжээнд төлөвшсөн; 	<ul style="list-style-type: none"> • Аливаа үйл ажиллагаа дүрэм журамд баригддаг тул өөрчлөлт хийх, хүлээн авах сонирхол, хүсэл эрмэлзэл бага; • Хяналтын системийг сайжруулах, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхой бус.

<ul style="list-style-type: none"> • Ажиллагсдыг улирал бүр гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлж урамшуулдаг; • Аливаа үйл ажиллагаа тушаал шийдвэр, захирах, захирагдах ёсны хэм хэмжээнд явагддаг. 	
4. ХҮНИЙ НӨӨЦ	
<ul style="list-style-type: none"> • Зохих түвшинд зөв төлөвшиж, туршлага хуримтлуулсан мэргэжлийн боловсон хүчинтэй; • Багаар ажиллах чадвартай; • Албан тушаалын тодорхойлолт батлагдсан, ажлын чиг үүрэг тодорхой; • Албан тушаалын ангилал, зэрэглэлийн дагуу цалинждаг; • Жил бүр гадаад, дотоодод богино хугацааны болон магистрын сургалтад албан хаагчдаас сургаж боловсон хүчнээ мэргэшүүлдэг; • Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэх эрх зүйн орчин бүрдсэн; • Байгууллагын талаар иргэдийн ойлголт харьцангуй сайн, нэр хүнд сайтай тул ажилд орох сонирхол нийгэмд нэмэгдсэн; • СЗХ-ны үйл ажиллагааны тайлант жилийн хагас болон жилийн тайланг хамт олондоо тогтмол танилцуулж, хэлэлцүүлдэг; • Хүний нөөцийн мэдээллийн системтэй; • Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа хэрэгждэг. 	<ul style="list-style-type: none"> • Албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийн түвшин дээшлүүлэх сургалтад хамруулдаг ч идэвх сул үр дүн муутай; • Шинээр өндөр боловсролтой, мэдлэг чадвартай боловсон хүчин ажилд орох магадлал бага; • Албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, идэвх санаачилга, өөрчлөлт хийх хүсэл эрмэлзэл хангалтгүй; • Сургаж, мэргэшүүлсэн боловсон хүчнээ тогтвортой ажиллуулж чадахгүй байна; • Хүний нөөц дутмаг; • Төсөв, санхүүгийн нөхцөлөөс шалтгаалж, албан хаагчдын нийгмийн баталгаа хангалтгүй, боловсон хүчин тогтвор суурьшилгүй; • Салбарын зохицуулалтад дэвшилтэд технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэхтэй уялдуулан СЗХ-ны мэдээллийн технологи чиглэлийн боловсон хүчин дутмаг.
5. ТЕХНИК, ТЕХНОЛОГИ	
<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа хэвийн явуулах материаллаг бааз хангагдсан; • Техник, технологийн ашиглалт сайн; • Байгууллагын цахим хуудас байнгын ажиллагаатай; • Байгууллагын дотоод сүлжээ, цахим сүлжээнд холбогдсон. 	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн нэгдсэн сан хангалтгүй; • Цахим орчны халдлагад өртөх магадлалтай; • Иргэдтэй харилцах болон санхүүгийн боловсрол олгох платформгүй.
6. АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ	
<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны байршил сайтай; • Ажлын байрны тохижилт, тодорхой хэмжээнд хийгдсэн; • Заал танхим, техник хэрэгслийн хангамж сайн. 	<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны агааржуулалт сул; • Албан хаагчдын төрийн өмч, хөрөнгөд өөриймсөг хандах хандлага сул.
7. САНХҮҮ	
<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр тогтвортой /улсын төсвөөс санхүүждэг/; • Төсвийн захиран зарцуулалт нээлттэй; • Аудит, татвар, нийгмийн даатгалын болон бусад холбогдох байгууллагын төлөвлөгөөт санхүүгийн шалгалт тогтмол хийгддэг; • Төрийн албаны цалингийн системд холбогдсон; • Олон улсын санхүүгийн байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд санхүү, техникийн туслалцаа авах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын үйл ажиллагаа улсын төсвөөс хамааралтай тул батлагдсан зарим төлөвлөсөн ажил тасалдах, дутуу биелэх зэрэг сөрөг нөлөөтэй.

3.2 ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Гадаад орчны шинжилгээнд улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүйн зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлж эерэг боломж, сөрөг нөлөөлөл, эрсдэлийг тодорхойлохыг зорьсон болно.

Боломж	Бэрхшээл /сорилт/
1. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРААС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЧИГЛЭЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	
<ul style="list-style-type: none"> • СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хууль, салбарын хууль, тогтоомж, УИХ, ЗГ-аас батлан гаргасан бодлогын баримт бичгүүд, СЗХ-ны баталсан дүрэм, журам, заавар зэрэг эрх зүйн орчин бүрдсэн; • Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн зохицуулалтын орчин, үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоо боловсронгуй болж, олон улсын нийтлэг жишигт нийцсэн; • Банкны салбарын реформын хүрээнд системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани болсноор чанартай шинэ бүтээгдэхүүний тоо, зах зээлийн үнэлгээ өсөж, олон тулгуурт санхүүгийн зах зээл бий болох эрх зүйн орчин бүрдсэн. 	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн салбарыг татвар, хураамжийн бодлогоор дэмжих хууль эрх зүйн орчин хангалтгүй; • СЗХ-ны бодлого боловсруулах чиг үүргийг хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй; • Бодлогын баримт бичиг боловсруулалт, хөгжүүлэлт дээр салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй.
2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН ХҮЧИН ЗҮЙЛС	
<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хэрэглэгчийн сонголт, эрэлт хэрэгцээ, итгэлийн индекс, зан төлөвийн өөрчлөлтүүд эерэг хандлагатай байна; • Эдийн засгийн өсөлт үргэлжлэх таамаглалууд зонхилж байна; • Хөрөнгө оруулагчдын оролцоо, идэвх, сонирхол нэмэгдсэн, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжил сайжирсан; • Мэргэжлийн байгууллага тул улс төрийн нөлөөлөл бага. 	<ul style="list-style-type: none"> • Ковид-19 цар тахал, Орос Украины дайнтай холбоотойгоор эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал үүссэн; • Инфляц нэмэгдэж үнийн хөөсрөл бий болсноор иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөх, үнэ нэмэгдэх, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт буурах; • Ажилгүйдэл, ядуурал буурахгүй байх, ажлын байрны хүртээмж багасах, иргэд өрийн дарамтад орох, дотоод хуримтлал өсөхгүй байх чанаргүй зээл өсөх; • Тээвэр ложистикийн зардал нэмэгдсэнээс, түүхий эдийн нийлүүлэлт, үнэ ханшид сөргөөр нөлөөлж, үл хөдлөх хөрөнгийн салбарт сөрөг нөлөөтэй байна; • Цаг уурын дулаарлаас үүдэн байгалийн гамшиг нэмэгдэх, ингэснээр санхүүгийн нөөцүүд буурах; • Хүн амын насжилтаас хамааран хуримтлалын бүтээгдэхүүнүүдийн үр ашиг багасаж, шимтгэл хураамж өсөх; • Давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр улс төрийн огцом шийдвэрээс шалтгаалан салбарын үйл ажиллагаа доголдох, салбарын активын чанар муудах, улмаар салбарт томоохон эрсдэлийг бий болгох.

3. ГАДААД ХАРИЛЦАА, ТҮНШЛЭЛ	
<ul style="list-style-type: none"> • Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжсөн; • Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжиж, салбарыг хөгжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байна; • Азийн бүс нутаг нь үл хөдлөх хөрөнгийн хийц, чанараар дээгүүр жагсдаг; • Монгол улс ихэнх хэрэглээний бүтээгдэхүүнээ гадаад зах зээлээс худалдаж (импортолж) авдаг. Үүнийг дагаад ачаа, бараа, тээврийн даатгал хурдацтай хөгжих боломжтой байна. 	<ul style="list-style-type: none"> • Гадаадын адил төстэй зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагаа хангалттай бус; • Импортын бүтээгдэхүүн нь сонголт ихтэй, хямд үнэтэй байгаа тул дотоодын үйлдвэрлэгчид зах зээлээ алдаж байна, ингэснээр төсөв, татвар, өр зээл, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд сөрөг нөлөөлөлтэй.
4. ТЕХНОЛОГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС	
<ul style="list-style-type: none"> • Дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд богино хугацаанд хүргэж байна; • Мэдээллийн сан бүрдэж, мэдээллүүд цахимжиж байна; • Үүрэн холбоо, цахим технологи, роботикс, хиймэл оюун ухаан, “The Internet of Things” зэрэг талбарууд хурдацтай хөгжиж байна; • Зээлийн цар хүрээг тэлэх, зээлийн эрсдэл, зардлыг бууруулж, хяналтыг сайжруулах чиглэлээр дижитал дэвшил санхүүгийн зах зээлд нэвтэрч байна. 	<ul style="list-style-type: none"> • Технологи, программ хангамж, техник технологийг ашиглахтай холбоотой мэдээллийн аюулгүй байдал хангалтгүй; • Технологийн чиглэлээр боловсон хүчин дутагдалтай, технологийн мэдлэг хангалтгүй; • Хөрөнгө эх үүсвэрийн зардал дутмаг.
5. ХАРИЛЦАГЧ, ХЭРЭГЛЭГЧ	
<ul style="list-style-type: none"> • Зохицуулалтын салбарын мэргэжлийн оролцогчид мэргэшин төрөлжиж байна; • Хэрэглэгчид гар утас, цахим төхөөрөмж ашиглан санхүүгийн үйлчилгээнд өргөн хамрагдаж байна; • Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, харилцагчдын тоо эрс өсөж, үүнтэй уялдан зах зээлийн эрэлт, нийлүүлэлт өргөжиж байна; • Банкнаас бусад санхүүгийн салбар дахь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний тоо, төрөл эрчимтэй өссөн. 	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн санхүүгийн харилцаан дахь эрх ашгаа хамгаалах мэдлэг сул; • Банкнаас бусад санхүүгийн зах зээл дээр ажиллаж буй хүний нөөцийн чадавх тааруу; • Иргэд санхүүгийн төлөвлөлт хийдэггүй, санхүүгийн хамгаалалт сул байгаагаас санхүүгийн эрсдэлд орох өндөр магадлалтай.

3.3 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны свот шинжилгээний үр дүн, баримтлах стратеги

Хүснэгт 5. Орчны шинжилгээний үр дүн

<p>SO – Санхүүгийн зохицуулах хорооны давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг ашиглах</p>	<p>WO - Гадаад орчны таатай боломжийг ашиглан Санхүүгийн зохицуулах хорооны сул талыг сайжруулах</p>
<ul style="list-style-type: none"> • Зохицуулалтын салбаруудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дэд бүтцийн хөгжлийг сайжруулах; • Менежментийн чадавхад суурилсан удирдлагын тогтолцоо, зохион байгуулалтын зохистой бүтцийг бүрдүүлэн, үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх; • Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг гадаад болон дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх; • Техник, технологийн ашиглалт, судалгаа, шинжилгээ, өнөөгийн мэдээллийн сан, материаллаг баазад тулгуурлан технологид суурилсан хяналт, шалгалтын системийг нэвтрүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд олон талт болон дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, эх үүсвэрийн зардлыг бууруулах замаар бүтээгдэхүүн үйлчилгээний хүүг бууруулах, иргэдэд хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээг хүргэх; • Салбарын мэдээллийн сан /мэдээллийн аюулгүй байдлыг хангах/-ийн дэд бүтцийг сайжруулах; • Санхүүгийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, дижитал үйлчилгээ нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; • Санхүү, бүртгэлийн программ болон мэдээллийн бааз, серверийг сайжруулж хяналт, шалгалт, бүртгэл, мэдээлэл, судалгаа шинжилгээ хийх цогц системийг бүрдүүлэх.
<p>ST- Санхүүгийн зохицуулах хорооны давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөлөөг даван туулах боломжийг ашиглах</p>	<p>WT- Гадаад орчны таагүй нөхцөлд Санхүүгийн зохицуулах хорооны сул талаа бууруулах замаар сөрөг үр дагаврыг багасгах</p>
<ul style="list-style-type: none"> • Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, боловсрол олгох, мэдээллийн тэгш бус байдлын зөрүүг багасгах; • Зохицуулалттай салбарын тогтвортой байдлыг сайжруулахын тулд зохицуулалтын байгууллагуудын эрсдэлийн үнэлгээ, удирдлагын тогтолцоог сайжруулах. 	<ul style="list-style-type: none"> • СЗХ-ны нэр хүндийг өргөх, мэргэжлийн чадавхыг дээшлүүлж иргэдийн итгэлийг олох нийгэмд эзлэх байр сууриа бэхжүүлэх; • Санхүүгийн зах зээлд оролцогч болон үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, олон улсын жишигтэй уялдуулах.

ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээсэн ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлооно.

ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ЗУРГАА. ҮНЭТ ЗҮЙЛС

Ёс зүй: Хүнлэг, үнэнч, шударга, сахилга баттай, бусдыг хүндэлдэг, ёс суртахуунтай байх;

Манлайлал, санаачилга: Манлайлагч, эрэлхийлэгч, шинийг санаачлагч, хөгжүүлэгч, бүтээлч байх;

Хариуцлага: Үүргээ бүрэн ухамсарлаж, хуулиа дээдэлдэг, хичээнгүй, нягт нямбай, ажлын зохин байгуулалт, цаг хуваарилалт сайн байх;

Мэргэшсэн: Мэдлэг, ур чадвар эзэмшсэн, дадлага туршлагатай, өрсөлдөх болон дасан зохицох чадвартай, өндөр бүтээмжтэй байх;

Бие даасан, ил тод: Хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, сонирхлын зөрчлөөс ангид, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч болон байгууллагын эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос өмнө тавин хараат бусаар үйл ажиллагаа явуулах;

Багийн ажиллагаа: Хамт олондоо хүндэтгэлтэй хандаж, мэдлэгээ хуваалцан дэмждэг байх.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ЗОРИЛГО 1.УЯН ХАТАН ЗОХИЦУУЛАЛТ, ЦАХИМ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ

Стратегийн зорилт 1.1.Санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх

" олон талт бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээл хоорондын уялдаа холбоог хангасан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

" зах зээлд фронтид, зохицуулалттай байгууллагуудын өрсөлдөх чадвар, үүрэг оролцоог нэмэгдүүлэх;

" цахим технологид суурилсан болон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих, технологийн стандартыг нэвтрүүлэх;

" олон улсын стандартыг нэвтрүүлж, сайн туршлагыг нутагшуулах.

Стратегийн зорилт 1.2.Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

" олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх олон улс, бүс нутгийн сайн туршлагыг нутагшуулах;

" их өгөгдлийг санбүрдүүлж, санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулах;

" 1.2.3.гарааны бизнесийг дэмжих гарааны хөрөнгийн сан болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох.

Стратегийн зорилт 1.3.Ногоон бүтээгдэхүүн, тогтвортой санхүүжилтийг дэмжих

" ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих;

" 2.хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой бизнесийн үйл ажиллагаа, ногоон зээл, ногоон санхүүжилт, инновацын тогтолцоог бүрдүүлэх.

ЗОРИЛГО 2.САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Стратегийн зорилт 2.1.Зохицуулалтын салбарын эрсдэлийн удирдлагыг сайжруулж регтек, суптекийг нэвтрүүлэх

" 1.эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг нэмэгдүүлж, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах;

" 2.1.2.их өгөгдөлд суурилсан хяналт шалгалтын систем болон регтек, суптекийг нэвтрүүлэх;

" 1.3.зохицуулалттай байгууллагуудын засаглалыг сайжруулах.

Стратегийн зорилт 2.2.Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын уялдаа холбоог хангах

" зохицуулагч байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах;

" нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх.

ЗОРИЛГО 3.ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

Стратегийн зорилт 3.1.Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулах

" хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчныг сайжруулах;

" мэдээлэл тайлагналын ил тод, үнэн зөв байдлыг хангах замаар санхүүгийн зах зээлд итгэх итгэл, оролцоог нэмэгдүүлэх;

" хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах.

ЗОРИЛГО 4.ҮНЭТ ЗҮЙЛСЭЭ ЭРХЭМЛЭСЭН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА БАЙХ

Стратегийн зорилт 4.1.Залгамж чанар бүхий мэргэшсэн баг бүрдүүлэх

" чадахуйц зорилд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэх;

" байгууллагын дотоод үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн мөрдүүлэх;

" дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх.

Стратегийн зорилт 4.2.Хорооны мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах

" Хорооны дотоод болон зөвшөөрөл, хяналтын үйл ажиллагааг цахимжуулах;

" мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан их өгөгдөлд суурилсан нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх.

Стратегийн зорилт 4.3.Хамтын ажиллагааг өргөжүүлэх

" гадаадын мэргэжлийн холбоод, ижил төстэй санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

" 2.төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой харилцан үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

НАЙМ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2022-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	№	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр	Хариуцах нэгж
ЗОРИЛГО 1: УЯН ХАТАН ЗОХИЦУУЛАЛТ, ЦАХИМ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ							
Стратегийн зорилт 1.1. Санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх							
Дэд зорилт 1.1.1. олон талт бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээл хоорондын уялдаа холбоог хангасан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	1	Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	1. Үнэт цаасны тухай хууль; 2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх	Улсын Их Хурлаас 2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан.	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ХЭЗХ
	2	Компанийн эрх зүйн орчныг сайжруулах	Компанийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт боловсруулах	Улсын Их Хурлаас 2011 онд Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.	Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах, хуулийн төсөлд санал хүргүүлэх, холбогдох уулзалт, хэлэлцүүлэгт тухай бүр хамтран оролцсон байна.	Улсын төсөв	ҮЦГ ХЭЗХ
	3	Даатгалын салбарын эрх зүйн орчныг шинэчлэх	1. Даатгалын тухай хууль; 2. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль; 3. Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох судалгааг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх	Даатгалын тухай хууль, Даатгалын зуучлалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан.	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ДГ ХЭЗХ

	4	Банк бус санхүүгийн байгууллагын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох судалгааг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж байна.	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ББСБГ ХЭЗХ
	5	Хадгаламж, зээлийн хоршооны салбарын эрх зүйн орчныг шинэчлэх	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох судалгааг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсантай холбогдуулан холбогдох хуулиудын нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан.	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ХЗХГ ХЭЗХ
	6	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч үйл ажиллагааны зохицуулалтын орчныг боловсронгуй болгох	Холбогдох журмуудыг хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж, батлуулах	Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг баталсан.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.	Улсын төсөв	ХШЗГ ҮЦГ ЗЗСХГ ХЭЗХ
	7	Санхүүгийн бус бизнесийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох	1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг зохицуулсан хууль; 2. Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төсөл боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх	Хуулийн төслүүдийг боловсруулахад Дэлхийн банкны санхүүжилтээр зөвлөх үйлчилгээ авахаар гадаад, дотоодын зөвлөхтэй гэрээ байгуулсан.	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ҮХХЗ ҮЭЗГ ХЭЗХ
	8	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлыг сайжруулах	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн танилцуулга, хуулийн төслийн үр	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ХЭЗХ

				нөлөөг үнэлэх ажлын тайлан, хуулийн төслийн тандан судалгаа болон дагалдаж өөрчлөлт орох хуулийн төслийг тус тус боловсруулсан. Хорооны зүгээс Дэлхийн банкнаас зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байна.			
9	Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх	Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулсан.	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ХЭЗХ КЗКХ	
10	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулж, ажлын хэсэгт ажилласан байх	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан.	Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэн эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ХЭЗХ ББСБГ ХЗХГ	
11	Салбар хоорондын эрх зүйн орчныг сайжруулах	Санхүүгийн салбарын болон бусад хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажилласан байх	Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан.	Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах, хуулийн төсөлд санал хүргүүлэх, холбогдох уулзалт, хэлэлцүүлэгт тухай бүр хамтран оролцсон байна.	Улсын төсөв	ХЭЗХ	
12	Шинэчлэгдсэн эрх зүйн орчинтой уялдуулан хяналт зохицуулалтын орчныг сайжруулах	Журам, зааврын төсөл боловсруулах	Хорооноос баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тухай бүр хянаж байна.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.	Улсын төсөв	ХЭЗХ	

Дэд зорилт 1.1.2. зах зээлд оролцогч, зохицуулалттай байгууллагуудын өрсөлдөх чадвар, үүрэг оролцоог нэмэгдүүлэх	13	Зээлийн батлан даалтын үйлчилгээнд бичил санхүүгийн байгууллагуудыг хамруулах	Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах талаар арга хэмжээ авч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Зээлийн батлан даалтын сантай гэрээ байгуулсан 8 ББСБ, 2 ХЗХ тоо байна.	Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамрагдсан ББСБ, ХЗХ тоо 20 дахин нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ББСБГ ХЗХГ
	14	Зохицуулалттай этгээдийн үүрэг, хариуцлага, санхүүгийн чадавхыг бэхжүүлэх	Холбогдох зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, боловсон хүчин, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах	Хорооны 2014 оны 8 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, 2019 оны 4 дүгээр тогтоолоор “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ыг тус тус баталсан.	Зохицуулалттай этгээдийн хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, жил бүр сургалт зохион байгуулсан байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ
	15	Амьдралын буюу урт хугацааны даатгалын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх	Даатгалын салбарт амьдралын буюу урт хугацааны даатгалын үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах	Даатгалын нийт хураамжийн орлогын 0.7 хувийг урт хугацааны даатгалын хураамжийн орлого эзэлдэг. Хувийн тэтгэврийн даатгалын тухай хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан.	Урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж, урт хугацааны даатгалын хураамжийн орлогын хэмжээ 30 хувиар өссөн байна.	Улсын төсөв	ДГ
	16	Татварын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Санхүүгийн салбарт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд татварын бодлогоор дэмжих талаар холбогдох байгууллагуудад санал, дүгнэлт хүргүүлсэн байх	-	Холбогдох байгууллагуудад санал хүргүүлж, хамтран ажилласан байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ ХЭЗХ

Дэд зорилт 1.1.3. цахим технологид суурилсан болон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих, технологийн стандартыг нэвтрүүлэх	17	Хөрөнгийн зах зээл дэх шинэ бүтээгдэхүүнийг дэмжих	Хамтын нээлттэй ХОС, биржээр арилжаалагддаг сан /ETF/, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сан /REIT/ зэрэг шинэ бүтээгдэхүүний зохицуулалтын орчныг бүрдүүлсэн байх	Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн гараагүй байна.	Хөрөнгийн зах зээл дэх шинэ бүтээгдэхүүний тоо 2 дахин өссөн байна.	Улсын төсөв	ҮЦГ
	18	Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалтын орчныг бий болгох	Бирж болон биржийн бус зах зээлд арилжаалагддаг үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журмыг боловсруулах	Эрх зүйн зохицуулалтын орчин бүрдээгүй.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ
	19	Зохицуулалтын байгууллагуудын технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих	Технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлсэн байх	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. “Ард актив” ХЗХ, “Гялс төгрөг” ХЗХ-ны бий болгож буй аппликейшнтэй танилцсан бөгөөд ХЗХ-дод нэгдсэн платформ үүсгэх талаар ЕСБХБ-нд хүргүүлсэн төслийн саналд тусгасан. Иргэдийн худалдан борлуулсан бүтээгдэхүүний төлбөрийн баримтыг татварын QR баримтаар олгох бүрдүүлсэн. 286 этгээдэд QR баримтыг хэвлэж байршуулсан. Даатгалын багц дүрэмд цахим хэлбэрээр даатгалын гэрээ байгуулах, түүнтэй холбогдох нөхцөл шаардлагыг тусгасан.	Технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах байгууллагын тоо, тус үйлчилгээг хүртэх иргэдийн тоо 20 хувиар нэмэгдсэн байна.	Технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах байгууллагын тоо, тус үйлчилгээг хүртэх иргэдийн тоо 20 хувиар нэмэгдсэн байна.	Улсын төсөв

	20	Технологийн стандартыг нэвтрүүлэх	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан blockchain analytics зайны хяналтын систем нэвтрүүлэх	-	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан зайны хяналтын системийг нэвтрүүлж, үйл ажиллагаанд оруулсан байна.		ХШЗГ ВХҮҮ Х МТХ
	21	Сэндбоксын зохицуулалтын орчинд бүтээгдэхүүн үйлчилгээг турших	Сэндбоксын зохицуулалтын орчинд бүтээгдэхүүн үйлчилгээг турших хүсэлтийг хүлээн авч, зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.	Сэндбоксын зохицуулалтын орчны журам, Сэндбоксын зөвлөлийн дүрмийг баталсан. Финтект суурилсан 13 санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авч туршилтад оруулсан.	Сэндбокс зохицуулалтын орчинд туршигдсан бүтээгдэхүүний тоо 2 дахин нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ХШЗГ ЗЭСХГ
Дэд зорилт 1.1.4. олон улсын стандартыг нэвтрүүлж, сайн туршлагыг нутагшуулах	22	Байгал орчин, нийгэм, засаглал /БОНЗ/-ын стандартыг нэвтрүүлэх	Хувьцаат компаниуд, даатгал, ББСБ-уудад БОНЗ-ын стандартыг мөрдүүлэхтэй холбоотой журам, зааврыг боловсруулах	ТоС холбоотой харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. БОНЗ стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн 2 банк бус санхүүгийн байгууллага байна.	БОНЗ стандартыг нэвтрүүлсэн байгууллагын тоо 2 дахин нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ББСБГ ХШЗГ
	23	Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх	Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой зохицуулалтын орчныг боловсронгуй болгох	Хувийн 26 ХОС, хамтын 2 ХОС байна.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна. Мэргэжлийн оролцогчид 30 хувиар нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ХШЗГ
	24	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох зохицуулалтын орчныг	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулах	Хорооны 2013 оны 529 тогтоолоор “Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ыг баталсан.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ХШЗГ

		боловсронгуй болгох			Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллагын тоо өссөн байна.		
	25	Даатгалын зах зээлд олон улсын стандарт, зарчмыг нэвтрүүлэх	Даатгалын тулгуур зарчмыг үе шаттайгаар нэвтрүүлэх	Даатгалын хууль тогтоомжид даатгалын тулгуур зарчим 50 хувь нэвтэрсэн.	Даатгалын хууль тогтоомжид даатгалын тулгуур зарчим 70 хувь нэвтэрсэн байна.	Улсын төсөв	ДГ
	26	Хадгаламж зээлийн хоршооны салбарт олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх	Тогтворжилтын сан, дундын санхүүгийн байгууллага байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бусад улсын үйл ажиллагаа, туршлагыг судалж, зохицуулалтыг тусгасан.	Тогтворжилтын сан, дундын санхүүгийн байгууллагын байгуулагдсан байна.	Улсын төсөв	ХЗХГ
	27	Олон улсын санхүүгийн байгууллагуудын стандарт, туршлагыг нэвтрүүлэх талаар судалгаа хийх	10-аас доошгүй орныг хамруулсан судалгаа хийх	2021 онд нэр бүхий 10 төрлийн судалгаа хийгдсэн.	Судалгаа хийж дүгнэлт, танилцуулгыг холбогдох удирдлагуудад танилцуулсан байна.	Улсын төсөв	ЗЗСХГ
	28	Компанийн засаглалыг зарчмыг боловсронгуй болгох	Компанийн засаглалын кодексийг шинэчлэх	-	Компанийн засаглалын кодексийг шинэчлэн боловсруулж, Хорооны хуралдаанд хэлэлцүүлсэн байна.	Улсын төсөв	КЗКХ ҮЦГ ББСБГ ХЗХГ ДГ
Стратегийн зорилт 1.2. Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх							
Дэд зорилт 1.2.1. олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд олон улс, бүс	29	Монгол Улсын Санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож дүгнэж байх	Хөтөлбөрийн биелэлт 67.7 хувьтай байна.	Хөтөлбөрийн биелэлтийг 90-ээс хувьд хүргэсэн байна.	Улсын төсөв	ЗЗСХГ

нутгийн сайн туршлагыг нутагшуулах	30	Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх	Иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох судалгаа, шинжилгээ хийж олон нийтэд түгээх	Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, БСШУ-ны сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015.10.07-ны өдрийн хамтарсан тушаалаар “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021”-ийг баталж, хэрэгжүүлсэн.	Хорооны цахим хуудсаар болон бусад цахим дамжуулан иргэдэд санхүүгийн мэдлэг олгоход чиглэсэн мэдээ, мэдээллийг төрөлжүүлэн ангилж байршуулсан байна.	Улсын төсөв	СБСА ЗУГ ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ ГХХАГ КЗКХ ХЭЗХ МТХ
Дэд зорилт 1.2.2. их өгөгдлийн сан бүрдүүлж, санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулах	31	Үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцооны системийн уялдаа холбоог сайжруулах	Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болон үнэт цаасны компаниудын арилжаа, төлбөр, тооцооны системийн уялдаа холбоо, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээ авч, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх	Хорооны 2020 оны 29 дүгээр тогтоолоор Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горимд шилжүүлж, олон улсын жишиг төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлсэн.	Үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамж буурч, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа, хөрвөх чадвар нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ХШЗГ
	32	Санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчдын хамтын ажиллагааг өргөжүүлэх	Салбарын бодлогын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, бодлогын зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжсон байх	-	Салбарын бодлогын зөвлөл жилд 4-өөс доошгүй хуралдсан байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ
	33	Даатгалын мэдээллийн сангийн эрх зүйг орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох	Даатгалын мэдээллийн сангийн эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын арга хэмжээ авч, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх	Жолоочийн даатгалын мэдээллийн сан бүрдсэн.	Жолоочийн даатгалын мэдээллийн санг өргөжүүлж, заавал даатгалын мэдээллийн сан үүсэх нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байна.	Улсын төсөв	ДГ
	34	Зээлийн мэдээллийн санд ББСБ, ХЗХ хамруулах	Зээлийн мэдээллийн санд хамрагдах байгууллагын тоог нэмэгдүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын 79.0 хувь, ХЗХ-дын 53.1 хувь нь зээлийн мэдээллийн санд хамрагдсан байна.	Тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын 85 хувь, ББСБ-уудын 90-ээс дээш хувийг зээлийн мэдээллийн санд хамруулсан байна.	Улсын төсөв	ББСБГ ХЗХГ

	35	Их өгөгдлийн сан бүрдүүлэх	Зохицуулалттай салбар бүрээр их өгөгдлийн сан бүрдүүлэх	-	Салбар бүрээр их өгөгдлийн сан бүрдүүлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ МТХ
Дэд зорилт 1.2.3. гарааны бизнесийг дэмжих гарааны хөрөнгийн сан болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох	36	Гарааны бизнест зориулсан хөрөнгө оруулалтын сан байгуулах	Гарааны бизнест хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай хөрөнгө оруулалтын сан байгуулж, ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх	-	Гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан байна.	Улсын төсөв	ҮЦГ ББСБГ ХЭЗХ
	37	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилтийн хэлбэрийг нэвтрүүлэх	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх (angel investment, venture capital fund), санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлсэн байх	-	Гарааны бизнес эрхлэгчдэд санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ
	38	Гарааны бизнесийг санхүүжүүлэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих	Гарааны бизнесийг санхүүжүүлэх Venture capital сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох	-	Гарааны бизнесийг санхүүжүүлэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ
Стратегийн зорилт 1.3 Ногоон бүтээгдэхүүн, тогтвортой санхүүжилтийг дэмжих							
Дэд зорилт 1.3.1. ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих	39	Санхүүгийн зах зээлд ногоон бүтээгдэхүүн бий болгоход бодлогоор дэмжин ажиллах	Санхүүгийн зах зээлд ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулснаар бүтээгдэхүүний тоо нэмэгдсэн байх	Хорооны 2021 оны 226 дугаар “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг баталсан. Дотоодын хөрөнгийн зах зээлд компанийн ногоон бонд гараагүй. АХБ-тай хамтран 2022-2024 онд хэрэгжүүлэх төслийн баримт бичгийг эцэслэсэн бөгөөд ХЗХ-ны салбарт ногоон санхүүжилттэй	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна. Ногоон бүтээгдэхүүний тоо нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ

				холбоотой зохицуулалтыг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийх, журам зааврыг төсөл боловсруулахаар тогтсон.			
Дэд зорилт 1.3.2. хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой бизнесийн үйл ажиллагаа, ногоон зээл, ногоон санхүүжилт, инновацын тогтолцоог бүрдүүлэх	40	Уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлээс хамгаалах бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих	Уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах	Үрийн тариалангийн даатгал, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хэрэгжиж байна.	Уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ДГ
	41	Ногоон эдийн засаг, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон инновацыг бодлогоор дэмжих	Салбарын үйл ажиллагаанд нийцсэн журам, аргачлал боловсруулсан байх	-	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ
ЗОРИЛГО 2. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ							
Стратегийн зорилт 2.1 Зохицуулалтын салбарын эрсдэлийн удирдлагыг сайжруулж регтек, суптекийг нэвтрүүлэх							
Дэд зорилт 2.1.1. эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг нэмэгдүүлж, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах	42	Үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах	Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах этгээдийн эрсдэлийн удирдлагын арга, аргачлалыг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулсан байх	Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ыг баталсан.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах этгээдийн эрсдэл дах чадвар сайжирсан байна.	Улсын төсөв	ҮЦГ ХШЗГ
	43	Эрсдэлд суурилсан хөрөнгө, даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн	Журам, аргачлалыг олон улсын стандарт, зарчимтай нийцүүлэн шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх	Хорооны 2019 оны 2 дугаар тогтоолоор баталсан Даатгалын багц дүрмийн 2 дугаар	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны	Улсын төсөв	ДГ

		чадвараа үнэлэх зохицуулалтыг боловсронгуй болгох		хавсралтаар Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмыг баталсан. Ажлын албаны даргын 2018 оны 290 дүгээр тушаалаар түр баталсан.	хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна.		
	44	Давхар даатгалын зохицуулалтын орчныг сайжруулах	Давхар даатгал болон даатгалын эрсдэл шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлагыг баталсан.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна	Улсын төсөв	ДГ
	45	ХЗХ-дын дотоод хяналтын тогтолцоог сайжруулах	ХЗХ-дод дотоод хяналтын тогтолцоог сайжруулахад өөрийн хоршооны эрсдэлийг үнэлэх асуулгын хуудас, зөвлөмж, заавар боловсруулах	АХБ-ны төслийн хүрээнд ХЗХ-дын дотоод хяналтыг сайжруулах 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	ХЗХ-дын эрсдэлийг үнэлэх зөвлөмж, заавар боловсруулсан байна.	Улсын төсөв	ХЗХГ
Дэд зорилт 2.1.2. их өгөгдөлд суурилсан хяналт шалгалтын систем болон регтек, суптекийг нэвтрүүлэх	46	Хувьцаат компани хэлбэртэй банкны үйл ажиллагааны зохицуулалтын орчныг бий болгох	Хувьцаат компани хэлбэртэй банкны үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах	Санхүүгийн зах зээлийн нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоонд шилжээгүй.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна. Хороо хувьцаат компани хэлбэртэй банкны үйл ажиллагаанд хяналт тавьж эхэлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ХШЗГ
	47	Зохицуулалтын салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах	Хяналт шалгалтын журам, аргачлалыг олон улсын стандарт, засаглалын зарчимтай нийцүүлэн шинэчилж, эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх	Олон улсын аргачлал, хяналт шалгалтын бодлогын баримт бичгийг судалсан. Зайны болон газар дээрх хяналт шалгалтын журмыг шинэчлэн төслийг боловсруулсан.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв	ХШЗГ ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ

			Эрсдэлийн хэмжээнээс хамааруулж хяналт шалгалтын давтамж, цар хүрээг үнэлж, тодорхойлох, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, сайжруулах зорилгоор технологид суурилсан программ хангамжийг нэвтрүүлэх	Хяналт шалгалтын программ хангамж байхгүй.	Технологид суурилсан хяналт шалгалтын программ хангамжийг нэвтрүүлсэн байна.		ХШЗГ
	48	Регтек, суптекийг нэвтрүүлэх талаар судлах	Их өгөгдөлд суурилсан регтек, суптекийг нэвтрүүлэх талаар холбогдох судалгаа хийх	-	Холбогдох судалгаа хийж танилцуулсан байна.	Улсын төсөв	ХШЗГ ЗЗСХГ
Дэд зорилт 2.1.3. зохицуулалттай байгууллагуудын засаглалыг сайжруулах	49	Зохицуулалттай байгууллагуудын засаглалын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох	Зохицуулалттай байгууллагуудын засаглалыг сайжруулах зохицуулалтыг тусгасан журам, заавар боловсруулах, сургалт зохион байгуулах	Холбогдох сургалтуудыг мэргэжлийн холбоодтой тогтмол зохион байгуулж байна.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ ХШЗГ КЗКХ
Стратегийн зорилт 2.2 Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын уялдаа холбоог хангах							
Дэд зорилт 2.2.1. зохицуулагч байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах	50	Зохицуулалттай салбаруудыг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох	Зохицуулалттай салбарыг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, холбогдох байгууллагатай хамтран ажиллах	Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 27 хууль, 111 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулж ажилласан.	Зохицуулалтын орчныг сайжруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ
	51	Салбарын холбоодтой хамтарсан сургалт зохион байгуулах, зохицуулалттай салбарт ажиллах мэргэжилтнийг чадавхжуулах	Хамтарсан сургалтыг зохион байгуулсан, статистик тоон мэдээ гарсан байх	2021 оны байдлаар эрх олгох 24 удаа зохион байгуулж 1809, мэргэшүүлэх 10 удаагийн сургалтад 260 мэргэжилтэн хамрагдсан байна.	Жил бүрийн тооцоо гарсан байна.	Улсын төсөв	ГХХАГ СБСА ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ ХШЗГ КЗКХ
Дэд зорилт 2.2.2. нэгдсэн хяналт шалгалтын эрх	52	Банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн хяналт шалгалтын	Банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдөгдөх захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журмуудыг хууль тогтоомжид	Хэм хэмжээний акт, Хорооноос баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг Захиргааны	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны	Улсын төсөв	ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ

зүйн орчныг бүрдүүлэх		зохицуулалтын орчныг боловсронгуй болгох	нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах	ерөнхий хуульд нийцүүлэн тухай бүр хянаж байна.	хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна.		ҮХХЗ ҮЭЗГ ХШЗГ КЗКХ ХЭЗХ
	53	Хяналт шалгалтын журам болон гарын авлага боловсруулж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөөт хяналт, шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжих хүрээнд зайны болон газар дээрх хяналт шалгалтын журам, гарын авлагын төслийг боловсруулж, батлуулах	-	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна	Улсын төсөв	ХШЗГ

ЗОРИЛГО 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

Стратегийн зорилт 3.1 Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулах

Дэд зорилт 3.1.1. хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчныг сайжруулах	54	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Иргэд, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгох	Холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэдэг.	Холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэсэн байна.	Улсын төсөв	ХШЗГ
	55	Санхүүгийн маргаан шийдвэрлэх механизмыг бий болгох	Санхүүгийн зах зээлийг бүхэлд нь хамарсан санхүүгийн маргаан шийдвэрлэх механизмыг бий болгосон байх	Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн дагуу уг асуудлыг хэлэлцэж байгаа бөгөөд холбогдох хуулийн төсөлд ажиллаж байна.	Санхүүгийн маргаан шийдвэрлэх механизм бий болсон байна.	Улсын төсөв	ХШЗГ ХЭЗХ
	56	Хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх ашгийн хамгаалах	Санхүүгийн зах зээлд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Санхүүгийн зах зээлд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Хадгаламж, зээлийн хоршооны мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын тухай хуулийн төслийг боловсруулсан.	Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн байна.	Улсын төсөв
Захиргааны хэрэг болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж төлөөлж оролцох			Иргэд, хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдсан.	Шүүх хуралдаанд оролцож, нэхэмжлэл, хариу тайлбар, нотлох баримтыг гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх	Улсын төсөв	ХЭЗХ	

					ашиг сонирхлыг хамгаалсан байна.		
Дэд зорилт 3.1.2. мэдээлэл, тайлагналын ил тод, үнэн зөв байдлыг хангах замаар санхүүгийн зах зээлд итгэх итгэл, оролцоог нэмэгдүүлэх	57	Иргэд олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах	Иргэд, хуулийн этгээдийг хууль тогтоомж, цаг үеэ олсон, хүртээмжтэй мэдээ, мэдээллээр хангах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулж, олон нийтэд хүргэх мэдээллийг олон улсын жишгийн дагуу маягтжуулсан. Санхүүгийн салбарын тоон мэдээллийг цахим хуудас, мэдээллийн санд байршуулсан.	Иргэд, олон нийт мэдээлэл, тайлагналыг ил тод, үнэн зөв, түргэн шуурхай авч санхүүгийн зах зээлд итгэх итгэл нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ХШЗГ ЗУГ ЗЭСХГ ГХХАГ ҮХХЗ ҮЭЗГ
			Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Даатгалын тухай болон даатгалын мэргэжлийн оролцогчдын тухай хуулийн дагуу даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлдэг.	Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлэх эрх зүйн орчин боловсронгуй болж, хэрэгжилт хангагдсан байна.	Улсын төсөв	ХШЗГ ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ
Дэд зорилт 3.1.3. хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах	58	Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах	Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хувийн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын хяналт, зохицуулалтын дүрэм, журмыг боловсронгуй болгох	Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахаар хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.	Журам, зааврын төслийг олон нийтэд хэлэлцүүлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна.	Улсын төсөв	ХШЗГ ХЭЗХ ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ
			Цахим халдлагаас урьдчилан сэргийлэх	Албан ёсны эрхтэй програмуудыг үйл ажиллагаанд нэвтрүүлж, ашиглах	Фина систем, Office 365, Windows 10, Windows Server, Kaspersky security center, Болор дуран зэрэг	Үйл ажиллагаанд ашиглаж буй албан ёсны программын тоо нэмэгдсэн байна.	Улсын төсөв

				программууд албан ёсны эрхтэй байна.			
ЗОРИЛГО 4: ҮНЭТ ЗҮЙЛСЭЭ ЭРХЭМЛЭСЭН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОХ							
Стратегийн зорилт 4.1. Залгамж чанар бүхий мэргэшсэн баг бүрдүүлэх							
Дэд зорилт 4.1.1. чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэх	60	Албан хаагчдын бүртгэл, мэдээллийн санг сайжруулах	Албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, хүйсийн ялгаа, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг нарийвчилсан мэдээлэл бүхий бүртгэлийн цахим систем бий болсон байх	Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем ашиглаж байна.	Үйл ажиллагаанд бүрэн нэвтэрсэн байна	Улсын төсөв	ЗУГ
	61	Чадахуйн зарчимд нийцсэн мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлж, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах	Хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх	СЗХ-ны 2019-2022 оны хооронд баримтлах “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг СЗХ-ны даргын 2018 оны 639 тоот тушаалаар баталсан.	Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлсэн байна.	Улсын төсөв	ЗУГ
			Эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	“СЗХ-ны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг СЗХ-ны Ажлын албаны даргын 2018 оны 249 тоот тушаалаар баталсан.	Хөтөлбөр хэрэгжсэн байна.	Улсын төсөв	ЗУГ
Дэд зорилт 4.1.2. байгууллагын дотоод үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн мөрдүүлэх	62	Үйл ажиллагааны дотоод дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг сайжруулах	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам, Санхүүгийн зохицуулах хорооны шагнал олгох, шагналын сан бүрдүүлэх, зарцуулах журам, СЗХ-ны улсын байцаагчийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны сургалтын журмуудыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангах	“СЗХ-ны Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам”-ыг СЗХ-ны даргын 2018 оны 341 тоот тушаалаар баталсан. “СЗХ-ны шагнал олгох, шагналын сан бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг СЗХ-ны 2015 оны 154 тоот тогтоолоор баталсан. “СЗХ-ны Улсын байцаагчийн дүрэм”-ийг СЗХ-ны 2015 оны 154 тоот тогтоолоор баталсан.	Холбогдох дүрэм журмыг шинэчлэн боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангасан байна.	Улсын төсөв	ЗУГ

				“СЗХ-ны албан хаагчдын сургалтын хөтөлбөр” -ийг СЗХ-ны Ажлын албаны даргын 2018 оны 249 тоот тушаалаар баталсан.			
Дэд зорилт 4.1.3. дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх	63	Дотоод аудитын үйл ажиллагаанд олон улсын стандартуудыг хэрэгжүүлэх	Дотоод Аудиторуудын Олон Улсын Институтээс батлан гаргасан удирдамжийн дагуу олон улсын стандартыг мөрдсөн байх	Дотоод аудитын олон улсын стандартыг үйл ажиллагаанд тодорхой түвшинд хэрэгжүүлж хэвшсэн.	Дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байна.	Улсын төсөв	ДАХ
	64	Эрсдэлд суурилсан дотоод аудитыг хэрэгжүүлэх аргачлал боловруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Дотоод аудитын олон улсын стандарт 2120 - Эрсдэлийн удирдлага, 2020 - Төлөвлөлт, SO31000:2009 - Эрсдэлийн удирдлага-Зарчим ба COSO загварыг ашиглаж мөрдсөн байх	Байгууллагын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэл өндөртэй объектыг сонгон аудитад хамруулах замаар эрсдэлд суурилсан аудитын арга хандлагыг ашиглаж байна. Эрсдэлд суурилсан дотоод аудит хийх аргачлалын төслийг боловсруулсан.	Эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой зөв тодорхойлж, аргачлал боловсруулан мөрдсөнөөр эрсдэлд суурилсан аудитыг хэрэгжүүлсэн байна. Байгууллагын удирдлага, нэгжийн удирдлага эрсдэлийг хэрхэн удирдаж байгаад дүгнэлт хийж, үйл ажиллагааг сайжруулахад зөвлөмж, дэмжлэг үзүүлсэн байна.	Улсын төсөв	ДАХ
Стратегийн зорилт 4.2. Хорооны мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах							
Дэд зорилт 4.2.1. Хорооны дотоод болон зөвшөөрөл, хяналтын үйл	65	Үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой асуудал, хэрэглэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтэд тулгуурласан эргэх холбоо бүхий үйл ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлж хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны 30 хувь цахимд шилжсэн.	Үйл ажиллагаа бүрэн цахимжсан байна.	Улсын төсөв	ХШЗГ ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ

ажиллагааг цахимжуулах			Тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй хүргэх	Тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлсэн.	Тоон гарын үсгийг бүрэн нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв	МТХ ХШЗГ
	66	Зайны болон газар дээрх хяналт шалгалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг тайлагнах	Хяналт, шалгалт заасан хугацаанд хийгдэж шалгалтын тайлангаар өгсөн үүрэг, даалгавар биелэгдсэн эсэх, хийгдсэн шалгалтын чанар, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулсан эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээний хийж дүгнэлт, санал зөвлөмж гарган, гүйцэтгэл үр дүнг сайжруулах	-	Хяналт шалгалтын чанарт үнэлгээ хийж, дүгнэлт өгсөн байна.	Улсын төсөв	ЗУГ ДАХ
Дэд зорилт 4.2.2. мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан их өгөгдөлд суурилсан нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх	67	Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах нэгдсэн системийг бий болгох	ISO 27001:2019 стандартыг үе шаттайгаар нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, технологийг бүрдүүлэх	Хорооны мэдээллийн аюулгүй байдал 50 хувь хангагдсан.	ISO 27001:2019 стандартыг бүрэн нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв	МТХ
	68	Төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох цахим тогтолцоог боловсронгуй болгох	Хур, Дан, E-Mongolia зэрэг цахим платформыг ашиглан мэдээлэл солилцох бүрэн боломжтой болсон байх	ББСБ, ҮХХЗҮЭЗ-ын салбарт мэдээлэл солилцох эхний алхам хийгдсэн.	Мэдээлэл солилцох бүрэн боломжтой болсон байна.	Улсын төсөв	МТХ
	69	Архив, цаасан хэлбэрийн мэдээллийн санг цахим хэлбэрт хөрвүүлэх	Архив, цаасан хэлбэрийн мэдээллийн санг цахим хэлбэрт хөрвүүлж, бүртгэлийн нэгдсэн санд нэгтгэх, архивын цахим сантай болсон байх	Эхлэл тавигдсан.	Мэдээллийн санг цахим хэлбэрт хөрвүүлсэн байна.	Улсын төсөв	МТХ
	70	Зохицуулалттай иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг сайжруулах	Зохицуулалттай иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, жигд ашиглах	Салбаруудын холбогдох бүртгэл, мэдээлэл орсон.	Нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Улсын төсөв	МТХ ЗЭСХГ ҮЦГ ДГ ББСБГ ХЗХГ ҮХХЗ ҮЭЗГ

Стратегийн зорилт 4.3. Хамтын ажиллагааг өргөжүүлэх

Дэд зорилт 4.3.1. гадаадын мэргэжлийн холбоод, ижил төстэй санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	71	Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах	Бодлого тодорхойлогч олон улсын байгууллагын олон талт харилцан ойлголцлын санамж бичигт нэгдэн орох, гадаадын ижил төстэй санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай санамж бичиг байгуулах, санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх	6 санамж бичиг байгуулсан.	Санамж бичгийн хүрээнд хийсэн үйл ажиллагааны тоо, хамрах хүрээ нэмэгдэж, хамтын ажиллагаа өргөжсөн байна.	Улсын төсөв	ГХХАГ
	72	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	ОУ-ын донор байгууллагууд (IFC, WB, ADB, EBRD, JICA)-тай хамтран хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтийг хангах, шинээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх	7 төсөл хэрэгжиж байна.	Төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан байна.	Улсын төсөв	ГХХАГ
Дэд зорилт 4.3.2. төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой харилцан үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	73	Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах	Хамтран ажиллах гэрээний тоо, хамтын ажиллагааны үр дүнгийн тайлан жил бүр гаргасан байх	Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	Хамтран ажилласан байгууллагын тоо нэмэгдэж, үр дүнгийн биелэлт тооцсон байна.	Улсын төсөв	ГХХАГ ЗУГ ҮЦГ ДГ ББСГ ХЗХ ҮХХЗ ҮЭЗГ
	74	Мэргэжлийн холбоодын чадавхыг бэхжүүлэх	Мэргэжлийн холбоодын чадавхыг бэхжүүлэх талаар хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	-	Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн байна.	Улсын төсөв	ГХХАГ ЗУГ ҮЦГ ДГ ББСГ ХЗХ ҮХХЗ ҮЭЗГ
	75	Төрийн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах, мэдээлэл солилцох	УИХ-ын ЭЗБХ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Монголбанканд зохицуулалтын салбарын тоон мэдээллийг тогтмол улирал бүр хүргүүлсэн байх	Зохицуулалтын салбарын тоон мэдээллийг улирал тутам хүргүүлдэг.	Улирал тутам хүргүүлсэн байна.	Улсын төсөв	ЗУГ ЗЗСХГ

ЕС. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА ХОЛБОО, ЗУРАГЛАЛ

Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 онд хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд нийт 3,440 зохицуулалттай этгээд, 2,403 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавин ажилласан бөгөөд эдгээр зохицуулалттай этгээдүүдээр дамжуулан иргэд, олон нийтэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж, тэдний санхүүгийн боловсролыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн СЗХ нь төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлж байна.

Хүснэгт 6. Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт

